- ・使用者が、この労働基準法で定められた労働時間（法定労働時間）を超えて労働させる場合（時間外労働）、または法定休日に労働（休日労働）させる場合には、時間外労働をさせる事由、業務の種類、延長することができる時間等について、事業場の労働者の過半数を代表する者（労働者の過半数で組織する労働組合がある場合は、その労働組合）と労使協定を締結し、所轄の労働基準監督署長に届け出ておかなければなりません。

iii. Илүү цагийн, бүх нийтээр амрах өдрийн нөхөн олговор

Ажил олгогч нь ажилчдад хуулиар тогтоосон цагаас илүү хөдөлмөр (илүү цагаар ажиллуулах) эрхлүүлсэн тохиолдолд нөхөн олговор олгох ёстой.

- i. Хуулиар тогтоосон ажлын цагаас илүү цагаар ажиллуулсан цагийг (илүү цагийн ажил) энгийн цалингийн 25%-с дээш хувиар тооцно.
 - ii. Хуулиар тогтоосон бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан цагийг (бүх нийтийн амралтын өдрийн ажил) энгийн цалингийн 35%-с дээш хувиар тооцно.
 - iii. Оройны 10 цагаас өглөөний 5 цаг хүртэл шөнө ажиллуулсан цагийг (шөнийн ажил) энгийн цалингийн 25%-с дээш хувиар тооцно.
- Тухайлбал, хуулиар тогтоосон ажлын цагаас гадуурх хөдөлмөр нь шөнийн ажил байвал (i.+iii.) олгогдох цалин нь 50%-с дээш хувиар тооцогдоно.

*Нэг сарын турш 60 цагаас илүү ажиллуулсан тохиолдолд илүү цагийн хөлс дээр 50%-с дээш хувийн нөхөн олговор олгоно. Түүнчлэн, Хөдөлмөрийн стандартын хуулийн 138-р зүйлд заасан жижиг ба дунд оврын үйлдвэрүүдийн хувьд хөнгөлөлттэй хандана.

* Хуулиар тогтоосон нөхөн олговрын хувийг хойшлуулах жижиг ба дунд оврын үйлдвэрүүд (ажлын байрны нэгжээр бус үйлдвэрийн нэгжээр шийдвэрлэнэ)

- i. Үндсэн хөрөнгийн дүн болон хөрөнгө
Жижиглэн худалдаа 50 сая иенээс доош
Үйлчилгээний салбар 50 сая иенээс доош
Бөөний худалдаа 100 сая иенээс доош
Дээрхээс бусад 300 сая иенээс доош
буюу
- ii. Тогтмол цагаар ажилдаг ажилчид
Жижиглэн худалдаа 50 хүнээс доош
Үйлчилгээний салбар 100 хүнээс доош
Бөөний худалдаа 100 хүнээс доош
Дээрхээс бусад 300 хүнээс доош

(3) Жил бүрийн ээлжийн цалинтай амралт

Ажил хийж эхлэснээс хойш 6 сараас дээш хугацаанд тасралтгүй ажиллаж, нийт ажлын өдрийн 80%-с дээш ажилсан бол тухайн ажилтан нь 10 хоногийн жил бүрийн ээлжийн цалинтай амралт авах эрхтэй.

Ажилласан жил	6 сар	1 жил 6 сар	2 жил 6 сар	3 жил 6 сар	4 жил 6 сар	5 жил 6 сар
Амрах өдрийн тоо	10 өдөр	11 өдөр	12 өдөр	14 өдөр	16 өдөр	18 өдөр

Зарчим ёсоор ажилтан нь ээлжийн цалинтай амралт авах үеийн талаар хүсэлт гаргах эрхтэй боловч, тухайн хугацаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол ээлжийн цалинтай амралтын өдрүүдийг өөрчлөх тохиолдол байж болно.

Энэхүү жил бүрийн ээлжийн цалинтай амралтыг ажил олгогч нь худалдаж авахыг хориглоно.

(4) Цалин

- Цалин олгох арга
 - Ажил олгогч нь цалин олгохдоо, i. цаасан мөнгө болон зоосоор ii. нийт дүнг iii. сар бүр нэгээс дээш удаа iv. тогтсон өдөрт v. тухайн хүнд шууд цалин олгоно

③時間外・休日割増賃金

使用者が労働者に法定時間外労働（残業）をさせた場合などには、割増賃金を支払わなければなりません。

- ①法定労働時間を超えて働かせた時間（時間外労働）は通常賃金の25%以上増し
- ②法定休日に働かせた時（休日労働）は通常賃金の35%以上増し
- ③午後10時から午前5時までの深夜に働かせた時（深夜労働）は通常賃金の25%以上増し

●例えば、法定労働時間外の労働かつ深夜労働であった場合（①+③）は、支給される賃金は50%以上増えます。

※1か月の間に60時間を超えて時間外労働をさせた場合には、その超えた時間の労働について50%以上の割増賃金を支払わなければなりません。なお、労働基準法第138条に規定する中小企業の事業については、当分の間、適用が猶予されます。

※法定割増賃金率の適用が猶予される中小企業（事業場単位ではなく、企業単位で判断します）

①資本金の額または出資の総額が

小売業	5000万円以下
サービス業	5000万円以下
卸売業	1億円以下
上記以外	3億円以下

または

②常時使用する労働者が

小売業	50人以下
サービス業	100人以下
卸売業	100人以下
上記以外	300人以下

(3) 年次有給休暇

雇用開始後6ヶ月以上継続して勤務し、全労働日の8割以上出勤した労働者には、10日間の年次有給休暇を取得する権利が与えられます。

勤務年数	6ヶ月	1年6ヶ月	2年6ヶ月	3年6ヶ月	4年6ヶ月	5年6ヶ月
付与日数	10日	11日	12日	14日	16日	18日

有給休暇は労働者の請求する時季に取得できるのが原則ですが、請求された時季に有給休暇を与えることが事業の正常な運営を妨げる場合においては他の時季に変更される場合があります。

なお、この年次有給休暇を使用者が買い上げることは禁止されています。

(4) 賃金

○賃金の支払い方法

- ・賃金の支払いについて、使用者は、①通貨で②全額を③毎月1回以上④決められた日に⑤直接本人に支払うことになっています。

- Гэхдээ дараах нөхцлийг бүгдийг хангасан бол цаасан мөнгө ба зоосоор бус банкаар шилжүүлж болно:
 - i. Тухайн хүний бичгээр үйлдсэн зөвшөөрөлтэй бол
 - ii. Тухайн хүний өөрийн нэрийн данс руу шилжүүлэг хийх
 - iii. Цалинг тогтоосон өдөрт төлөх боломжтой
 - iv. Цалингийн баримт (дэлгэрэнгүй хуудас) гаргаж өгнө
 - v. Банкны дансанд шилжүүлэхтэй холбоотой ажилтан ба ажил олгогч хоорондын гэрээтэй бол
- Хуулиар тогтоосны дагуу цалингаас татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ажил эрхлэлтийн даатгалын хураамж зэргийг суутгана. Түүнчлэн эхний ээлжинд ажилтан ба ажил олгогч хоорондын гэрээ байгуулагдсан бол байр хоолны төлбөр цалингаас шимтгэгдэнэ.
- (*) “Цалин тооцох талаарх мэдлэг” (46-р хуудсыг үзнэ үү)
- Хянагч байгууллагын дадлага хэрэгжүүлэгч газраас суутгах хяналтын зардлыг ур чадварын дадлагажигч төлөх ёсгүй тул цалингаас нь суутгаж үл болно.

Хяналтын зардлын талаар (тайлбар)

Хуульд заагдсан гадаад иргэдийн ур чадварын дадлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд зарцуулах зардлыг хэлнэ. Хянагч байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч газар эдгээр зардлыг даах тул ур чадварын дадлагажигчийн сургалтын тэтгэлэг болон цалингаас суутгахгүй болно.

- Цалингийн дүн
 - Ажил олгогч нь цалингийн хамгийн доод хэмжээний хуулиар нийслэл, хот, мужийн нэгжийн хэмжээнд тогтоосон цалингийн хамгийн доод хэмжээнээс дээш дүнг төлөх ёстой.

Цалингийн доод хэмжээний талаар (тайлбар)

- Цалингийн доод хэмжээ нь орон нутгийн цалингийн доод хэмжээ ба тусгай бүс нутгийн цалингийн доод хэмжээ гэсэн 2 төрөлд хуваагдана. Хоёр төрөлд нэгэн зэрэг хамаарах бол ажил олгогч нь аль илүү их дүнтэй төрлийн цалингийн доод хэмжээний дүнгээс илүү цалин олгохгүй бол болохгүй.
 - i. Орон нутгийн цалингийн доод хэмжээ: Аж үйлдвэр болон ажлын төрлөөс үл хамааран нийслэл, хот, мужийн бүх ажилчид болон ажил олгогчдод хамаарах цалингийн доод хэмжээг хэлнэ. 2017 оны 4-р сарын байдлаар Токиод 932 иен, Окинавад 714 иен зэрэг нийслэл, хот, муж тус бүрээр ялгаатай байна.
 - ii. Тусгай бүс нутгийн цалингийн доод хэмжээ: Тусгай бүс нутаг дахь тусгай аж үйлдвэрийн ажилчдад хамаарах цалингийн доод хэмжээг хэлнэ.
- Цалингийн доод хэмжээтэй харьцуулах арга:

Цагийн хөлс авдаг бол	Цагийн хөлс \geq цалингийн доод хэмжээ (цагаар)
Өдрийн хөлс авдаг бол	Өдрийн хөлс \div 1 өдрийн тогтсон ажлын цаг \geq цалингийн доод хэмжээ (цагаар)
Сарын хөлс авдаг бол	Сарын хөлс \div 1 сарын дунджаар тогтоосон ажиллах цаг \geq цалингийн доод хэмжээ (цагаар)

Нийт орон даяарх цалингийн хамгийн доод хэмжээний талаар дараах вэб сайт болон ойр очимд байрлах Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас лавлаж болно.

“Цалингийн доод хэмжээний талаар тусгайлан гаргасан Япон хэл дээрх вэб сайт”
<http://pc.saiteichingin.info/>

- ・ただし、以下の条件を全て満たす場合は、通貨払いではなく口座振込みも認められます。
 - ①本人の書面による同意を得る
 - ②本人が指定する本人名義の預金口座に振り込む
 - ③賃金支給日として決められた日に払出しができる
 - ④賃金計算書(明細書)を交付する
 - ⑤口座振込に関する労使協定の締結があること
 - ・また、税金、社会保険料、雇用保険料等は、法令に従い給与から控除されます。その他、あらかじめ労使協定が締結されている場合は、宿舍費や食事費等も給与から控除されます。
- (※)「賃金計算の知識」(47ページも参照ください)
- ・なお、監理団体が実習実施者から聴取することとなる監理費については、技能実習生が負担すべきものではなく、賃金から控除してはいけません。

【解説】監理費について

法令で定められた外国人技能実習制度を実施するための業務にかかる経費のことです。これらは、技能実習生が負担すべき費用ではなく、監理団体や実習実施者が負担するものなので、講習手当や賃金から控除されることはありません。

○賃金額

- ・賃金額については、使用者は最低賃金法により都道府県単位で定められた最低賃金額以上を支払わなければなりません。

【解説】最低賃金について

○最低賃金には、地域別最低賃金と特定最低賃金の2種類があります。なお、両方が同時に適用される場合には、使用者は高い方の最低賃金額以上の賃金を支払わなければなりません。

①地域別最低賃金: 産業や職種にかかわらず各都道府県の全ての労働者とその使用者に適用される最低賃金です。2017年4月現在、東京は932円、沖縄は714円など、職場のある都道府県によって違います。

②特定最低賃金: 特定地域内の特定の産業の労働者とその使用者に適用される最低賃金です。

○最低賃金額との比較方法

時間給の場合 時間給 \geq 最低賃金額(時間数額)

日給の場合 日給 \div 1日の所定労働時間 \geq 最低賃金額(時間額)

月給の場合 月給 \div 1か月平均所定労働時間 \geq 最低賃金額(時間額)

全国の最低賃金については下記のインターネットのホームページ又はお近くの労働基準監督署で確認ができます。

【最低賃金に関する特設サイト(日本語)】

<http://pc.saiteichingin.info/>

- Ур чадварын дадлагажигчийн хувьд цалингийн доод хэмжээний тухай хууль болон Хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн дагуу цалингаа бодуулах нь зүй ёсны хэрэг боловч Ур чадварын дадлагын тухай хуулинд “Ур чадварын дадлагажигчийн авах цалин хөлсний дүн Япон хүн ажилсантай ижил буюу түүнээс дээш хэмжээнд байна” хэмээн тогтоосон байна.
- Илүү цагийн, бүх нийтийн амралтын өдрийн нөхөн олговор олгох:
 - Илүү цагаар ажилсан, хуулиар тогтоосон бүх нийтийн амралтын өдөр ажилласан, шөнийн цагаар ажилсан бол (2) iii. “Илүү цагийн, бүх нийтийн амралтын өдрийн нэмүү өртөг”-ийн талаар дурьдсан нэмүү өртөгийн цалинг авна.
- Чөлөө авах үед төлөх нөхөн олговор
 - Дадлага хэрэгжүүлэгчийн хариуцлагаас болж чөлөө олгогдох үед, тухайн хугацаанд дундаж цалингийн 60%-аас дээш хэмжээний чөлөөний нөхөн олговрыг танд олгох болно гэж тусгагдсан байна.
- Төлөгдөөгүй цалинг өмнөөс нь төлөх
 - Дадлага хэрэгжүүлэгч газар дампуурсны улмаас цалингаа авалгүйгээр ажлаасаа гарсан ажилчны хувьд цалингийн төлбөрийг хангах хуулинд үндэслэн төлөгдөөгүй байгаа цалингийн нэг хэсгийг өмнөөс нь төлөх тогтолцоо бий. Энэхүү тогтолцоогоор ямар нөхцлийн дор цалин олгогддог мөн хэмжээний талаар хамгийн ойр байрлах нийслэл, хот, мужийн Хөдөлмөрийн товчооны харьяа Хөдөлмөрийн стандартын хэлтэс, Хяналтын хэлтэс болон Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас лавлана уу.
- Хууль тогтоомжоор хориглосон бусад зүйлс

Дараах зүйлс нь Хууль тогтоомжоор хориглосон байна:

 - i. Хөдөлмөрлөж төлнө гэсэн нөхцөлтэйгөөр өмнө зээлсэн мөнгийг цалингаас суутгах
 - ii. Хүчээр банкинд мөнгө хадгалуулах
 - iii. Ажил олгогч болон хянагч байгууллага нь тухайн хүний нэр дээрх хадгаламжийн дэвтэр зэргийг хураан авч хадгалах

“Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам, Хөдөлмөрийн стандартын вэб сайт (англи хэл, бусад)”

http://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/index.html

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам

Гадаадын иргэдэд зориулсан утасны лавлах үйлчилгээний талаар 70-р хуудаснаас үзнэ үү.

12. Нийгмийн даатгал

Нийгмийн даатгал гэдэг нь өвчин тусах, гэмтэж бэртэхэд гарсан эмчилгээний зардал болон өвчин, гэмтлийн улмаас нас барсан, нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд тэтгэврийн төлбөрөөр дамжуулан даатгал төлөгч болон түүний гэр бүлийн амьдралын баталгаа гаргах улсын тогтолцоог хэлнэ.

(1) Нийгмийн даатгалын төрөл ба төлбөр

	Төрөл	Төлбөр
Эмчилгээний даатгал	Эрүүл мэндийн даатгал Улсын эрүүл мэндийн даатгал	<ul style="list-style-type: none"> • Өвчин болон гэмтлээс үүдэн гарсан эмчилгээний зардлын нэг хэсгийг (70 нас хүртэл 70%) даатгалаар төлнө (өврийн зүгээс гаргах эмчилгээний зардал нь 30% болно). * Ажлын үеэр болон ажил явах үед ямар нэг өвчин тусч гэмтэл авсан бол Хөдөлмөрийн гэнэтийн ослын нөхөн төлбөр төлөх даатгалаас өгөгдөнө. Энэ тохиолдолд эмчилгээний зардлын бүх дүнг Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгалаас төлнө.
Тэтгэвэр	Нийгмийн халамжийн тэтгэвэр Улсын тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> • Хөгшрөх, хөгжлийн бэрхшээл, нас барахтай холбогдуулан шаардлагатай төлбөрийг (тэтгэвэр олгох) олгоно.

- 技能実習生に対しては、最低賃金法をはじめ労働関係法令を遵守した賃金の支払いを行う必要があることは当然ですが、技能実習法では、「技能実習生に対する報酬の額が日本人が従事する場合の報酬の額と同等以上であること」と定めています。
- 時間外・休日割増賃金の支払い
 - ・時間外労働・法定休日労働、深夜労働を行った場合には、「(2) ③時間外・休日割増賃金」で述べた割増賃金が支払われます。
- 休業手当の支払い
 - ・実習実施者の責めに帰すべき事由による休業の場合においては、実習実施者は休業期間中、あなたに平均賃金の60%以上の休業手当を支払わなければならないとされています。
- 未払賃金の立替払い
 - ・実習実施者の倒産により、賃金が支払われないまま退職した労働者に対して、賃金の支払の確保等に関する法律に基づき、未払賃金の一部を立替払する制度があります。この制度で立替払を受けることができる方の要件や対象となる未払賃金などの詳細については、最寄りの都道府県労働局労働基準部監督課又は労働基準監督署にお問い合わせください。
- その他の法令等の禁止事項

以下の事項が法令等で禁止されています。

 - ①労働することを条件とする前貸の債権と賃金の相殺
 - ②強制預金を行うこと
 - ③使用者や監理団体が本人名義の預金通帳等を預かること

【厚生労働省 労働基準ホームページ(英語・その他)】

http://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/index.html

【厚生労働省 外国人向け相談ダイヤル】

71ページをご覧ください。

12. 社会保険

社会保険とは、病気やケガの療養費、また、病気やケガが原因で死亡した場合や一定の障害状態になった場合の年金の支払等を通じて加入者や遺族の生活を保障する国の制度です。

(1) 社会保険の種類と給付

	種 類	給 付
医療保険	健康保険 国民健康保険	○病気やケガにより生じる医療費の一部(70歳までは70%)を保険で負担します(自己負担は医療費の30%となります)。 ※仕事上や通勤による病気やケガについては、労働者災害補償保険から給付が行われます。この場合、医療費の全額を労災保険で負担します。
年 金	厚生年金 国民年金	○老齢・障害・死亡に関して必要な給付(年金の支給)を行います。

(2) Нийгмийн даатгалд хамрагдах ажилчид

Хамрагдах ажилчид	
Эрүүл мэндийн даатгал Нийгмийн халамжийн тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> • Дараах ажилчид хамрагдана: <ul style="list-style-type: none"> - Аж ахуйн нэгж - Ердийн үед 5-с дээш ажилчинтай хувиараа хөдөлмөр эрхлэгч (газар тариалан, ой мод, загасны аж ахуй, буудал, цэвэрлэгээ зэрэг аж ахуй явуулдаг газар нь хамрагдахгүй) газар
Улсын эрүүл мэндийн даатгал Улсын тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> • Дээрхээс гадуурх аж ахуйн нэгжийн ажилчид (*) Улсын тэтгэврийн хувьд 20-с дээш насны ажилчид нь хамрагдана.

- Та(Ур чадварын дадлагажигч) “Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн халамжийн тэтгэвэр” эсвэл “Улсын эрүүл мэндийн даатгал болон улсын тэтгэвэр” багцын аль нэгэнд нь хамрагдах ёстой.
- Түүнчлэн сургалтанд хамрагдаж байгаа ур чадварын дадлагажигч нь “Улсын эрүүл мэндийн даатгал болон улсын тэтгэвэр”-г хамрагдах болно.

(3) Нийгмийн даатгалын шимтгэлийн дүн

Төрөл	Тайлбар	Даатгалын хураамжийн хувь	Даатгалын хураамжийн дүн (сарын дүн) Таны зүгээс төлөх дүн
Эрүүл мэндийн даатгал	<ul style="list-style-type: none"> • Сарын стандарт цалингийн дүнг (анхааруулга1) даатгалын хураамжийн хувь үржүүлсэн дүн нь сарын даатгалын төлбөр болно. • Сарын даатгалын төлбөрийг аж ахуй эрхлэгч (дадлага хэрэгжүүлэгч газар) болон та (ур чадварын дадлагажигч) таллан хувааж төлнө. 	Улсын Эрүүл Мэндийн Даатгалын Төвөөс хот суурин дахь даатгалын хураамж тогтоосон байна	Сарын стандарт цалингийн дүн×даатгалын хураамжийн хувь ×1/2
Нийгмийн халамжийн тэтгэвэр		18.182%	Сарын стандарт цалингийн дүн×18.182×1/2
Улсын эрүүл мэндийн даатгал	<ul style="list-style-type: none"> • Хот, дүүрэг, суурин, хороо тус бүрт тохирсон аргаар тооцно. 		хот дүүрэг хороогоор ангилан тогтоосон дүн (анхааруулга 2)
Улсын тэтгэвэр	<ul style="list-style-type: none"> • Бүх улс орон даяар нэгдсэн байдлаар тогтоогдсон байна. 		16,490 иен (анхааруулга 3)

(анхааруулга 1) “Сарын стандарт цалингийн дүн” нь та (ур чадварын дадлагажигч) 1 сард авах нийт цалингийн дүн дээр үндэслэн тогтоогдоно.

(анхааруулга 2) Улсын Эрүүл Мэндийн Даатгалын Төвийн даатгалын хураамжийн хувь нь нийслэл, хот, мужаар ангилбал (Сага муж) 10.47%-(Нийгата муж) 9.69% байна. (2017 оны 3-р сарын байдлаар) Мөн Нийслэл, хот, мужаар ангилсан даатгалын төлбөрийн талаар доорх вэб сайтаас лавлаж харж болно.

“Нийт улс даяарх эрүүл мэндийн даатгалын нийгэмлэгийн (Кэнпо нийгэмлэг) вэб сайт”
<http://www.kyoukaikenpo.or.jp/>

(анхааруулга 3) Даатгалын хураамжийг ур чадварын дадлагажигч та бүгдийг өөрөө төлнө. Ажил олгогч буюу дадлага хэрэгжүүлэгч газар төлөхгүй болно.

(2) 社会保険の対象となる従業員

	対象となる従業員
健康保険 厚生年金	○以下の事業所の従業員 ・法人事業所 ・常時5人以上の労働者を雇用する個人経営の事業所（農林水産業、旅館、クリーニング等の事業所は除きます。）。
国民健康保険 国民年金	○上記以外の事業所の従業員 (※)国民年金については、20歳以上の従業員のみが対象となります。

○あなた（技能実習生）は、「健康保険と厚生年金の両方」または「国民健康保険と国民年金の両方」のいずれかに加入しなければなりません。

○なお、「講習期間中」の技能実習生は、「国民健康保険と国民年金」に加入することになります。

(3) 社会保険料の額

種類	説明	保険料率	保険料の額（月額） あなたの負担額
健康保険	○標準報酬月額（注1）に保険料率をかけた額が月額の保険料となります。	協会けんぽの場合は、都道府県ごとに保険料が定められています。	標準報酬月額× 保険料率×1/2
厚生年金	○月額の保険料を事業主（実習実施者）とあなた（技能実習生）が折半して負担します。	18.182%	標準報酬月額× 18.182×1/2
国民健康保険	○市区町村ごとに定められた方法で算定します。		市区町村ごとの方法で算定した額（注2）
国民年金	○全国一律で決まっています。		16,490円（注3）

（注1）「標準報酬月額」は、あなた（技能実習生）の受け取る1ヶ月の総支給額に基づき決定されます。

（注2）協会健保の保険料率は、都道府県ごとの保険料は10.47%（佐賀県）～9.69%（新潟県）となっています（平成29年3月現在）。なお、都道府県別の保険料は下記のホームページで確認できます。

【全国健康保険協会（協会けんぽ）ホームページ】

<http://www.kyoukaikenpo.or.jp/>

（注3）保険料は全てあなた（技能実習生）の負担となります。事業主（実習実施者）の負担はありません。

(4) Нийгмийн халамжийн даатгал, улсын тэтгэврээс хасалт хийлгэхдээ авах төлбөрийг нэг дор нэхэмжлэх нь

- Нийгмийн халамжийн тэтгэврийн даатгал болон улсын тэтгэвэрт 6-с дээш сар хамрагдаж байгаад тэтгэвэр авах хугацаанаас өмнө нутаг буцах бол тэтгэврээс хасалт хийлгэхдээ авах төлбөрийг нэг дор нэхэмжилж болно. Тиймээс нутаг буцахаас өмнө төлбөр буцааж авах нөхцлийг нягталж үзнэ үү. Япон улсын тэтгэврийн байгууллага нь нэхэмжлэлийг хүлээн авах өдөр Японд оршин суух хаягтай байж болохгүй нөхцөлтэй тул нутаг буцахаас өмнө оршин сууж байгаа хот, дүүрэг, хороон дээр очиж хаягийн шилжилтийн мэдүүдэг өгөх хэрэгтэй. Хэрэв нутаг буцахаас өмнө Японд байхдаа нэхэмжлэл гаргавал Япон улсаас шилжин явах тухай бичигдсэн оршин суугчийн тодорхойлолтын хуулбар ба оршин суух бүртгэл цуцлагдсан хуудас зэрэг хот, дүүрэг, хороонд шилжилт хийлгэхээр мэдүүлсэн баримтыг хавсарган, оршин суугчийн тодорхойлолтын шилжилт хийгдэхээр байгаа өдрөөс хойш Япон улсын тэтгэврийн байгууллагад өгнө үү.

3-р зэргийн дадлагажигч болох төлөвлөгөөтэй бол хувь хүний хүслээс хамааран, ур чадварын 2-р зэргийн дадлага дүүргэсэн болон 3-р зэргийн дадлага дүүргэсний дараа нутаг буцах бол нэхэмжлэх боломжтой. Нэхэмжлэлийг Япон улсын тэтгэврийн байгууллагад өгөхөөс өмнө дахин Японд нэвтрэн орж, оршин суух хаягтай болсон бол тухайн төлбөр нэхэмжлэх боломжгүй болно.

Япон улстай нийгмийн баталгааны гэрээ байгуулсан улсуудад (тайлбар)

Япон улстай тэтгэвэрт орох хугацааг нийтэд нь болгосон нийгмийн баталгааны гэрээг байгуулсан тэтгэвэрт хамрагдах хугацаатай хүний хувьд, хоёр улсын тэтгэвэрт хамрагдах хугацааг нийтэд нь тооцон, Японы тэтгэврийг авах боломжтой.

Хэрэв тэтгэврээс хасалт хийлгэхэд авах төлбөрийг авах юм бол тус төлбөрийг нэхэмжлэхээс өмнөх тэтгэвэрт орох хугацааг нийтэд нь тооцож чадахгүй болно. Тийм учраас энэ төрлийн нэхэмжлэл гаргах бол анхаарах зүйлстэй сайтар танилцана уу.

- Тэтгэврийн хасалтын нэг дор авах төлбөрийн дэлгэрэнгүйг Япон улсын тэтгэврийн байгууллагын вэб сайтаас үзнэ үү. Түүнчлэн энэхүү вэб сайтаас “тэтгэврээс хасалт хийлгэхэд төлбөрийг нэг дор нэхэмжлэх” (улсын тэтгэвэр/нийгмийн халамжийн тэтгэврийн даатгал) үйлчилгээг авч болно. Дадлага хэрэгжүүлэгч ба хяналтын байгууллагын хариуцсан хүнд хандан “тэтгэврээс хасалт хийлгэхэд төлбөрийг нэг дор нэхэмжлэх” (улсын тэтгэвэр/нийгмийн халамжийн тэтгэврийн даатгал) өргөдлөө өгнө үү.

Япон улсын тэтгэврийн байгууллагын вэб сайт
<http://www.nenkin.go.jp/index.html>

AIR MAIL

Japan Pension Service (Foreign Business Group)

3-5-24, Takaido-nishi, Suginami-ku

Tokyo 168-8505 JAPAN

〒168-8505 東京都杉並区高井戸西3丁目5番24号

日本年金機構(外国業務グループ)

(4) 厚生年金保険、国民年金の脱退一時金の請求手続

○厚生年金保険又は国民年金に6ヶ月以上加入していた方が、年金の受給に必要な資格期間を満たさずに帰国した場合は、脱退一時金を請求することができますので、帰国する前に受給要件等を確認してください。

脱退一時金の受給要件として、日本年金機構が請求書を受理した日に日本に住所を有していないことが必要ですので、帰国前にお住まいの市区町村に転出届を提出してください。なお、帰国前に日本国内から請求書を提出される場合には、日本国外に転出予定である旨が記載された住民票の写しや住民票の除票等、市区町村に転出届を提出したことを確認できる書類を添付し、住民票の転出(予定)日以降に日本年金機構へ提出してください。

第3号技能実習生となる予定の方については、本人の希望により、技能実習2号修了後及び技能実習3号修了後の帰国の都度、請求していただくことが可能です。ただし、請求書を日本年金機構が受理する前に再入国し、住所を有するに至った場合には受給要件を満たさなくなるのでご注意ください。

【解説】日本と社会保障協定を結んでいる国の方々へ

日本と年金加入期間を通算する社会保障協定を結んでいる国の年金加入期間がある方については、両国の年金加入期間を通算して日本の年金を受け取ることができる場合があります。

しかし、脱退一時金を受け取ると、脱退一時金を請求する以前の年金加入期間を通算することができなくなります。このため、脱退一時金を請求する際には脱退一時金請求書の注意書きをよく読んで慎重に検討してください。

○脱退一時金についての詳細は、以下の日本年金機構のホームページをご覧ください。また、このホームページから「脱退一時金請求書(国民年金/厚生年金保険)」を入手できます。実習実施者又は監理団体の担当者に依頼して、「脱退一時金請求書(国民年金/厚生年金保険)」の手続を進めてください。

【日本年金機構ホームページ】

<http://www.nenkin.go.jp/index.html>

AIR MAIL

Japan Pension Service (Foreign Business Group)

3-5-24, Takaido-nishi, Suginami-ku

Tokyo 168-8505 JAPAN

〒168-8505 東京都杉並区高井戸西3丁目5番24号

日本年金機構(外国業務グループ)

13. Хөдөлмөрийн даатгал

Хөдөлмөрийн даатгал гэдэг нь ажлын дундуур болон ажилд явах зуур гэмтэх, өвчин тусвал олгогдох (хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгал) болон ажилгүй болсон тохиолдолд олгогдох (хөдөлмөрийн даатгал) улсын тогтолцоог хэлнэ.

Нэг ч гэсэн ажилчинтай аж ахуйн нэгж нь хүчээр орно.

Газар тариалан, ой мод, загасны аж ахуйн нэгэн хэсгийн тухай (тайлбар)

Газар тариалан, ой мод, загасны аж ахуйн нэгэн хэсгийн тухайд гэвэл хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгал нь сайн дурын даатгал байх ба энэ тохиолдолд хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгалыг орлуулах хувийн сайн дурын даатгалд хамрагдахгүй бол болохгүй.

(1) Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгал

- Ажилтан нь ажлаа хийх зуур эсвэл ажилдаа явах зуур осолд орвол тухайн ажилтан болон үлдэж буй гэр бүлийн хамгаалалд шаардлагатай төлбөр олгогдоно.
 - Уг даатгалд орох процедурыг ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч) хариуцна.
- Даатгалын хураамжийг ажил олгогч төлөх тул таны (ур чадварын дадлагажигч) зүгээс төлөгдөхгүй.

(2) Ажил эрхлэлтийн даатгал

- Ажилтан нь ажилгүй болсон тохиолдолд амьдралын тогтвортой байдлыг хангахын төлөө шаардлагатай төлбөр өгнө. Дадлага хэрэгжүүлэгч дампуурсан эсвэл ажил багассан гэх зэрэг шалтгааны улмаас ажилгүй болсон бол зарим нөхцөл хангасан тохиолдолд дадлагажигч нь хүртэл нөхөн олговор авах боломжтой.
 - Тус даатгалд орох процедурыг ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч) хариуцна.
 - Ажил эрхлэлтийн даатгалын хураамжийг ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч) болон ажилтан (ур чадварын дадлагажигч) төлнө. Дадлагажигч таны төлөх ёстой дүн нь дараах байдалтай байна: Цалин×даатгалын хувь (энгийн аж ахуй-0.3%, газар тариалан, ой мод, загасны аж ахуй-0.4%, барилгын ажил-0.4%)
 - Даатгалын хураамжийн хувьд ажил олгогч буюу дадлага хэрэгжүүлэгч нь таны төлөх ажил эрхлэлтийн даатгалын хураамжийг цалингаас суутган улсад тушаана.
- (*) “Цалин тооцох тухай мэдлэг”-г 46-р хуудаснаас үзнэ үү.

14. Орлогын албан татвар, оршин суугчийн албан татвар

- Ур чадварын дадлагажигч нарт цалинтай холботой улсын татвар болох орлогын албан татвар болон орон нутгийн татвар буюу оршин суугчийн албан татвар хамаарна. Үүнийг Японд оршин суугаа, орлоготой иргэд төлөхгүй бол болохгүй татвар юм.
- Орлогын албан татварыг сар бүрийн цалин дээрээс тодорхой хэмжээний мөнгөн дүнг хасан тооцно. 12-р сард тухайн жилийн цалингийн нийт дүнд хамаарах татварыг хассан дүнтэй тааруулан, зөрүү мөнгийг нөхөн төлөх эсвэл буцаан олгодог байна.
- Оршин суугчийн албан татварыг өнгөрсөн жилийн орлогод ноогдуулан бодох ба 2 дахь жилийн 1-р сарын 1 өдөр оршин суух орон нутгийн засаг захиргаанаас тодорхойлсон дүнг 12 удаа хуваан, 6 сараас хойшхи сар бүрийн цалингаас суутган төлнө.
- Ажил олгогч нь оршин суух хугацаанд сар бүрийн цалингаас татварын мөнгийг суутган, улс болон орон нутгийн захиргаанд төлнө. Хэрэв санхүүгийн жилийн дундаас нутаг буцах болвол аль хэдийн тогтоогдсон байгаа оршин суугчийн албан татварын үлдэгдлийг төлөхгүй бол болохгүй. Хэрэв Япон улсад нэг жилээс бага хугацаанд амьдарч байгаа бол өөр тогтолцоог дагана.
- Дэлгэрэнгүйг “Төрөл бүрийн зөвлөгөө, тусламж үзүүлэх цэг”-н 4-с асуух эсвэл дадлага хэрэгжүүлэгч газар, хянагч байгууллагаас лавлана уу.

13. 労働保険

労働保険とは、仕事中や通勤中のケガや病気に対する給付（労災保険）と失業した場合の給付（雇用保険）を行う国の制度です。

労働者を一人でも雇用している事業に対して強制的に適用されます。

【解説】農林水産業の一部について

農林水産業の一部については、労災保険が任意適用とされていますが、この場合、労災保険の代替措置として民間の任意保険に加入しなければなりません。

(1) 労災保険

- 労働者が業務上又は通勤途上で被災した場合に、労働者本人やその遺族を保護するために必要な給付が行われます。
- 加入手続きは使用者（実習実施者）が行います。保険料は使用者が全額負担することとなっていますので、あなた（技能実習生）の負担はありません。

(2) 雇用保険

- 労働者が失業した場合に生活の安定を図るため必要な給付を行います。実習実施者の倒産や事業の縮小などの理由で失業した場合に、一定の条件を満たしていれば、技能実習生も給付を受けることができます。
- 加入手続きは使用者（実習実施者）が行います。
- 雇用保険料は使用者（実習実施者）と労働者（技能実習生）で負担します。あなた（技能実習生）の負担額は以下のとおりです。
賃金額×保険率（一般の事業0.3%、農林水産の事業0.4%、建設の事業0.4%）
- 保険料の納付については、使用者（実習実施者）があなたの負担する雇用保険料を賃金から控除（徴収）し、国へ納付します。
（※）「賃金計算の知識」（47ページ）もご覧ください。

14. 所得税・住民税

- 技能実習生に関係する税金には、賃金に対する国税（所得税）と地方税（住民税）があります。これは、日本に居住していて、かつ、所得のある人が支払わなければならない税金です。
- 所得税は、毎月、賃金の支払額に応じた税額が賃金から天引きされ、12月にその年中の賃金の総額に対する税額と天引きした税額との調整を行い、差額徴収又は返還金の支給が行われます。
- 住民税は、前年の所得に対してかかる税金で、2年目の1月1日時点で住んでいる地方公共団体に対し、確定した税額を12回に分けて、6月以降の毎月の賃金から天引きされ、支払われます。
- 納税に当たって、在留中は毎月の給料から使用者が控除して、国や地方公共団体に支払います。年度途中で帰国する場合、住民税は既に年間の税額が確定しているので、年度分の残額を納付しなければなりません。
なお、日本滞在が1年未満の場合は、これらについて別の取扱いとなります。
- 詳しくは、「◎各種相談・支援窓口」の4にお尋ねいただくか、実習実施者又は監理団体にお尋ね下さい。

Цалин тооцох талаарх мэдлэг

Дадлага хэрэгжүүлэгч газраас (аж ахуй) та бүхэнд сарын цалингийн нийт дүнгээс нийгмийн даатгалын шимтгэл (эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжийн даатгал), ажил эрхлэлтийн даатгал, орлогын албан татвар, оршин суугчийн албан татвар болон зарим тохиолдолд байрны төлбөр, тог, газ, усны төлбөр хураамж хасч олгодог. Байр болон тог, газ, усны төлбөр зэрэг байнгын төлөх төлбөрийн хувьд төлбөрийн агуулгыг сайтар ойлгосны үндсэн дээр дадлага хэрэгжүүлэгч газартай (аж ахуй) хамтран зөвшилцсөн байх ба нийт зардал нь бодит зардалтай нийцсэн байх шаардлагатай.

Харин Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгалын хураамжийг ажил олгогч өөрөө төлөх учир цалингаас хасагдахгүй.

Цалин олгогч нь банкны дансаар цалинг шилжүүлэх тохиолдолд цалин авагч танд “цалингийн тооцооны баримт”-г заавал өгнө. “Цалингийн тооцооны баримт” нь дараах 4 хэсгээс бүрдэнэ:

Тэмдэглэгээ	Тайлбар	
Ажлын холбогдолтой тэмдэглэгээ	Ажилсан өдөр, ажлаас чөлөө авсан өдөр, ажилсан цаг (ажил хийсэн цаг), илүү цагаар ажилсан зэрэг	} Нийт цалингийн дүнг тооцно
Цалингийн тэмдэглэгээ	Үндсэн цалин, илүү цагаар ажилсан төлбөр зэрэг	
Hàng mục khấu trừ	Нийгмийн даатгалын шимтгэл (эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжийн даатгал, хөдөлмөрийн даатгал)	} Суутгасан дүнг тооцно
	Татвар (орлогын албан татвар, хотын иргэний татвар)	
Зөрүү хасагдсан мөнгөн дүн (гар дээр авах цалин)	Олгох нийт дүн -суутгасан нийт дүн	

Дараах татварыг төлнө:

Татварын дүн	
(Улсын татвар)	Нийт олгогдох дүнгээс үндсэн дүн болон эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамжийн даатгал, ажил эрхлэлтийн даатгалын хураамжийг хасч, үлдсэн мөнгөнд ноогдуулах татварын хувь болно. Жилд ноогдуулах татварын тогтсон хэмжээ 1,950,000-с доош 5% ----- 3,300,000-с доош 10% - 97,500иен (* Татварын гэрээгээр татвараас чөлөөлөгдөх боломжтой. (* Улсын эрүүл мэндийн даатгал, улсын тэтгэврийн даатгалын хураамжийг Татварын газарт мэдүүлвэл нийт төлөгдөх дүнгээс хасагдана.
(Оршин суугчийн албан татвар)	Оршин суугчийн албан татварын дүнг хот, дүүрэг, хорооноос мэдэгдэнэ. (* Татварын гэрээгээр чөлөөлөгдөх тохиолдол бий.

賃金計算の知識

実習実施者(企業)からあなたに支払われる毎月の賃金は、支給総額から社会保険料(健康保険料、厚生年金保険料)、雇用保険料、所得税、住民税、場合によっては宿舍費、光熱水道費などが差し引かれたものです。宿舍費や水道光熱費などあなたが定期的に負担する費用については、実際に提供を受けるものの内容を理解した上で、実習実施者(企業)との間で合意を得たものであって、かつ当該費用が実費に相当する額その他適正な額の範囲であることが求められます。

なお、労災保険の保険料は、全額使用者が負担しますので、賃金から差し引かれることはありません。

賃金を支払う者は、口座振込みより賃金を支払う際、あなた(支払いを受ける者)に「賃金計算書」を交付しなくてはならないとされています。「賃金計算書」は大きく、以下の四つから構成されています。

項目	内訳説明	
勤務項目	出勤日数、欠勤日数、労働時間(就業時間)、残業時間など	➔ 支給合計額を計算します。
支給項目	基本給、時間外手当(残業手当)など	
控除項目	社会保険料(健康保険、厚生年金保険、雇用保険)	➔ 控除合計額を計算します。
	税金(所得税、市民税)	
	協定控除(宿舍費、水道高熱費)	
差引支給額(手取り賃金)	支給合計額－控除合計	

納付する税額は以下のとおりです。

税 額							
(国税)	<p>支給総額から基礎控除額及び健康保険料、厚生年金保険料、雇用保険料等を差し引き、その差し引き後の金額に該当する税率となる。 [年間税額の目安]</p> <table> <tr> <td>195万円以下</td> <td>5%</td> <td>-----</td> </tr> <tr> <td>330万円以下</td> <td>10%</td> <td>-97,500円</td> </tr> </table> <p>(※) 租税条約で免除される場合があります。 (※) 国民健康保険料、国民年金保険料は税務署に確定申告などを行えば、支給総額から差し引かれます。</p>	195万円以下	5%	-----	330万円以下	10%	-97,500円
195万円以下	5%	-----					
330万円以下	10%	-97,500円					
(住民税)	<p>住民税の金額は市区町村から通知された金額 (※) 租税条約で免除される場合がある。</p>						

15. Эрүүл мэндийн үзлэг

“Үгийн Тайлбар” 15,16-д гарах “дадлага хэрэгжүүлэгч” нь “ажил олгогч” болно.

Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн хуулийн дагуу ажил олгогч нь энгийн үед ажиллуулах ажилтанг авахдаа эрүүл мэндийн үзлэгт заавал хамруулсан байна. Түүнчлэн ажил олгогч нь ажилчдаа жилд нэг удаа (ажлын төрлөөс хамаарч хагас жилд нэг удаа) тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулна. Ажлын агуулгаас хамаарч энэхүү тогтмол эрүүл мэндийн үзлэгээс гадна онцгой эрүүл мэндийн үзлэгт мөн хамруулах ёстой.

Эдгээр эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг ажил олгогч гаргана. Энгийн үед ч эрүүл мэнддээ хяналт тавих үүднээс эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж заншицгаа.

16. Ур чадварын дадлагын явц дахь үйлдвэрийн ослоос сэргийлэх нь

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн тухай хуульд зааснаар ажил олгогч нь ажлаас шалтгаалан гэмтэх эсвэл өвчин тусгахгүй байх арга хэмжээ авах үүрэгтэй. Түүнчлэн ажилтан нь үйлдвэрийн ослоос сэргийлэхэд шаардлагатай зүйлсийг дагаж мөрдөн, ажил олгогчийн авах арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр заасан байна.
- Дараах зүйлсэд анхаарлаа хандуулан ажлын үеэр бэртэхгүйн тулд аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, ажилдаа анхаарал болгоомжтой хандах нь чухал юм (дэлгэрэнгүйг ур чадварын дадлага удирдагчаас асууна уу).
 - i. Ажлын байран дахь тогтсон дүрэм болон ажлын дэс дарааллыг сахина.
 - ii. Ур чадварын дадлага удирдагчийн удирдамжийг дагана.
 - iii. Тогтсон хамгаалалтын малгай, маск, аюулгүйн бүс зэрэг хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.
 - iv. Аюулгүйн бүрхүүл, шатны бариул зэрэг аюулгүйн хэрэгсэл тоноглолыг дур мэдэн салгахгүй байна.
- Ажлын байранд үйлдвэрийн осол гарсан тохиолдолд та дараах зүйлд анхаарлаа хандуулан, нэн даруй зохистой арга хэмжээ авч, хүн болон эд зүйлсийн хохирлыг хамгийн багаар хязгаарлах нь туйлын чухал юм (дэлгэрэнгүйг ур чадварын дадлага удирдагчаас асууна уу).
 - i. Хэвийн биш зүйл ажиглагдсан бол чанга дуугаар ойр хавийн хүмүүст (ур чадварын дадлагажигч, бусад Япон хүмүүс) мэдэгдэхээс гадна ур чадварын дадлагын удирдагчтай холбоо барина.
 - ii. Чахилгаанд цохиулах, хүчилтөрөгч дутагдах тохилдолд туслах гэж оролдсон хүн давхар аюулд оруулах эрсдэлтэй. Тиймээс хариуцсан ажилтан зааврыг даган, ямар нэг арга хэмжээг дур мэдэн авч болохгүй.
 - iii. Осолд өртсөн хүнийг аврах, тусламж үзүүлэхийг эн тэргүүнд тавина.
 - iv. Жижиг гэлтгүй гэмтлийг ур чадварын дадлага удирдагчид заавал мэдэгдэх ёстой.
- Ажил олгогч нь үйлдвэрийн ослоос хамгаалахын тулд дараах (1)-(6) хүртэлх арга хэмжээг авна.



(1) Дадлага ажлын байран дээрх аюулгүй байдлын гол арга хэмжээ

- i. Хүрэхэд аюултай газар аюулгүйн бүрхүүл, хашлага зэргийг байрлуулсан байдаг.
 - * Аюулгүйн бүрхүүлийг авч үл болно. Хэрэв авах шаардлага гарвал зааварлагчид мэдэгдэнэ үү.
- ii. Аюултай газар биеийн нэг хэсгийг оруулах бол орсон хойно төхөөрөмж ажиллахгүй байхад анхаар.
 - * Аюулгүйн тоноглолыг үл хайхарч болно. Ажил эхлэхээс өмнө шалгаж үзнэ үү.
- iii. Бэлэн бус бүтээгдэхүүн хагарч сэтэрсний улмаас үеэрч ойж ирэх, үртэс үсрэх зэргээг ажилтанд аюултай гэж үзсэн тохиолдолд тоног төхөөрөмжийг бүтээх, халхлах шаардлагатай.
 - * Тоног төхөөрөмжийг бүтээх, халхлах боломжгүй үед, ажилтан хамгаалалтын хувцас хэрэглэх шаардлагатай.

15. 健康診断

【用語の説明】 15, 16において「実習実施者」は「使用者」に該当します。

労働安全衛生法では、使用者は、常時使用する労働者を雇い入れるときに、健康診断を行わなければならないとされています。また、使用者は労働者に対し、通常一年に一回（業務の内容によっては半年に一回）定期的に健康診断を行わなければならないとされています。さらに、業務の内容によっては、この定期健康診断以外に特殊健康診断も受診させなければならないとされています。

これらの健康診断の費用は、使用者が負担します。普段の健康管理のためにも、健康診断は必ず受診するようにしましょう。

16. 技能実習中の労働災害防止

- 労働安全衛生法は、仕事の原因となって労働者がケガをしたり、病気になったりしないように、使用者が措置しなければならない義務を定めています。また、労働者は、労働災害を防止するために必要な事項を守り、使用者が行う措置に協力するように定めています。
- あなたは、次の点に留意の上、作業中にケガをしないよう、安全を最優先に細心の注意を払いながら作業を進めていくことが重要です。（詳しくは、技能実習指導員に確認してください。）
 - ①決められた事業場のルールと作業手順を守ること。
 - ②技能実習指導員等の責任者の指示を守ること。
 - ③決められたヘルメット、マスク、安全帯等の保護具等をきちんと着用すること。
 - ④安全カバー、手すり等の安全装置や機器等を勝手に外さないこと。
- また、職場において労働災害の発生等緊急事態が発生した場合には、あなたは次の点に留意の上、迅速で適切な対応を心がけ、人の被害やものの被害を最小限に抑えることが重要です。（詳しくは、技能実習指導員に確認してください。）
 - ①異常を発見したら、大声で周りの人（技能実習生、日本人ほか）に知らせるとともに、技能実習指導員に連絡すること。
 - ②感電、酸素欠乏災害等の場合には、救助者が被災する二次災害の危険があります。責任者の指示に従い、勝手な行動をしないこと。
 - ③被災者の救出と手当を優先すること。
 - ④どんなに小さなケガでも技能実習指導員に報告すること。
- 使用者は、労働災害を防止するために、次に示す(1)から(6)の措置を行っています。



(1) 実習現場での主な安全対策

- ①接触すると、危険な箇所に安全カバー・囲いを取り付けることとなっています。
 - *安全カバーを外さないこと。外す必要がある場合は指導員に連絡してください。
- ②危険な箇所に体の一部が入る場合は、入っている間機械が作動しないようにすることとなっています。
 - *安全装置を無効にしない。作業前には、点検を徹底してください。
- ③加工物などが切断・欠損して飛来したり、切削屑が飛来したりして、労働者に危険を及ぼすおそれのあるときは、機械に覆いや囲いを設けることとなっています。
 - *機械に覆いや囲いを設けることが難しい場合は、労働者は保護具を使用しなければなりません。

iv. Тоног төхөөрөмжийн үзлэг, засвар, цэвэрлэгээ, тослогоо хийхээс өмнө төхөөрөмж унтарсан эсэхийг шалгана уу.

*Тоног төхөөрөмжийн үзлэг, засвар, цэвэрлэгээ, тослогоо зэрэг байнгын бус ажлыг дураар гүйцэтгэж болохгүй. Зааварлагчийн удирдлага дор хийсэн тохиолдолд ч гэсэн унтраалгыг бүрэн унтарсан эсэхийг шалгасны дараа гүйцэтгэнэ.

v. Дээрээс юм унах аюултай газар бариул суурилуулдаг.

*Бариул байхгүй бол зааварлагчтай холбоо барих ба энэ хооронд тэнд зогсох эсвэл ажил хийхийг хориглоно.

*Дээрээс юм унах аюултай газар угсардаг шат болон бариул суурилуулах нь бэрхшээлтэй тохиолдолд ажилтан нь аюулгүйн бүс хэрэглэх ёстой.

vi. Гагнуур хийхэд хамгаалалтын шил болон бээлий өмсөх ёстой.

vii. Хортой органик бодистой харьцдаг ажилтан нь өөрийн ажлын төрлөөс хамааран хамгаалалтын хувцас, хамгаалалтын нүдний шил, амьсгалын хамгаалах тоноглол зэрэг зүй зохистой тоноглолтой байх ёстой.

(2) Аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай боловсрол

Ажлын байрны аюулгүй байдлыг хангахын тулд анхаарах зүйл болон үндсэн дүрэм журам тогтоодог хэдий ч бодит байдал дээр ажил хийж байгаа ажилтан нь аюулгүй байдлын талаар мэдлэг болон үр чадварыг бүрэн дүүрнээр эзэмшээгүй бол аюулгүйн арга хэмжээ илүү үр дүнтэй байж чадахгүй. Тиймээс аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох боловсрол олгох нь үйлдвэрийн ослоос сэргийлээд зогсохгүй маш чухал ач холбогдолтой юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн тухай хууль

i. Ажилд орох үеийн боловсрол
59-р заалт, 1-р зүйл

ii. Ажил үүргийн хуваарь өөрчлөгдөх үеийн боловсрол
59-р заалт, 2-р зүйл

iii. Тусгай боловсрол
59-р заалт, 3-р зүйл

Ахлагчаас олгох боловсрол
60-р заалт

Аюултай ажил хийдэг ажилтанд олгох боловсрол
60-р заалт, 2-р зүйл

i. Ажилд орох үеийн боловсрол

ii. Ажил үүргийн хуваарь өөрчлөгдөх үеийн боловсрол

Ажил олгогч нь үр чадварын дадлагажигчийг ажилд авах үед болон ажил үүргийн хуваарь өөрчлөгдөхөд i. Тоног төхөөрөмж болон орцтой хэрхэн харьцах арга ii. Аюулгүйн тоноглол болон хамгаалалтын багажтай харьцах арга iii. Ажлын агуулга зэрэг үр чадварын дадлагажигчийн аюулгүй байдал болон эрүүл мэндийг хамгаалахад аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх боловсрол олгохгүй байдаг.

Ажилд орох үед болон ажил үүргийн хуваарь өөрчлөгдөх үеийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсролын заалт

- i. Тоног төхөөрөмж, аюултай, хортой бодистой орц найрлагатай хэрхэн харьцах арга зам талаар
- ii. Аюулгүйн тоноглол, хортой бодисыг хянах тоноглол ба хамгаалах хэрэгслийн багтаамж, ашиглах арга
- iii. Ажлын дэс дараа
- iv. Ажил эхлэхээс өмнө үзлэг хийх
- v. Тухайн ажилтай холбогдуулан тусч болох өвчний шалтгаан, урьдчилан сэргийлэлт
- vi. Эмх цэгц, цэвэрлэгээг хангах
- vii. Ослын үед авах яаралтай арга хэмжээ, зугатах зэрэг
- viii. Өмнөх хэсэгт дурдсан зүйлсээс гадна тухайн ажилтай холбоотой аюулгүй байдал, эрүүл мэндэд чухал шаардлагатай зүйлс


iii. Тусгай боловсрол

Аюултай, хортой ажил хийх тохиолдолд тусгай боловсрол олгоно.

- ④機械の点検・修理・清掃・給油等の場合は、スイッチを切って機械が止まっていることを確認してから行ってください。
 ＊機械の点検・修理・清掃・給油等の非正常作業は、勝手に行わないこと。指導員の指導の下で行う場合でもスイッチを切って機械等が完全に止まってから行うこと。
- ⑤墜落危険場所には手すりを設置することになっています。
 ＊手すりがない場合は指導員に連絡し、その間、立入・作業を止めて下さい。
 ＊墜落危険場所に足場や手すりなどを設けることが困難な場合、労働者は安全帯を使用しなければなりません。
- ⑥溶接の作業をする場合には、労働者は保護眼鏡と保護手袋を着用しなければなりません。
- ⑦有害な有機溶剤を取り扱う業務では、その業務の内容に応じて、労働者は保護衣、保護眼鏡、呼吸用保護具など適切な保護具を着用しなければなりません。

(2) 安全衛生教育

事業場においては、安全に業務を遂行するために注意事項や基本ルールなどが定められていますが実際に作業を行う労働者が安全についての知識や技能を十分に有していないと、いくら安全対策を講じても効果を上げることはできません。このため、安全に関する知識を付与する安全衛生教育は労働災害を防止する上で大変重要なものです。



①雇入れ時教育、②作業内容変更時教育

使用者は技能実習生を雇い入れた時や技能実習の作業内容を変更したときには、①機械や原材料などの取り扱い方法、②安全装置や保護具等の取扱い方法、③作業内容など、技能実習生の安全衛生の確保に必要な事項について、安全衛生教育を実施しなければなりませんとされています。

雇入れ時、作業内容変更時の安全衛生教育項目

- ①機械等、原材料等の危険性又は有害性及びこれらの取扱い方法に関する事
- ②安全装置、有害物抑制装置又は保護具の性能及びこれらの取扱い方法に関する事
- ③作業手順に関する事
- ④作業開始時の点検に関する事
- ⑤当該業務に関して発生するおそれのある疾病の原因及び予防に関する事
- ⑥整理・整頓及び清掃の保持に関する事
- ⑦事故時等における応急措置及び退避に関する事
- ⑧前各号に掲げるもののほか、当該業務に関する安全又は衛生のために必要な事項

③特別教育

また、危険・有害な業務に従事する場合は、特別教育を受講する必要があります。

Тусгай боловсрол шаардлагатай ажил

- Өргөгч цамхаг (5-с бага тонн жинтэй ачаа өргөх) жолоодох
- Зөөврийн өргөгч цамхаг (1-с бага тонн жинтэй ачаа өргөх) жолоодох
- Өргөгч цамхагийн өргөх ачааг бэлдэх ажил (1-с бага тонн жинтэй ачаа өргөх өргөгч цамхаг, зөөврийн өргөгч цамхаг зэрэг)
- Сэрээт ачигч зэрэг ачааны машин (хамгийн дээд тал нь 1-с дээш тонн) жолоодох
- Механик хөдөлгүүртэй пресс-н хэв цутгах, салгах, тохируулах
- Нум гагнагч ашиглах металлын гагнуур хийх
- Өндөр газар олс ашиглах ажил зэрэг

(3) Ажилд хэрэгтэй сертификат

Сертификатгүй бол ажил хийх боломжгүй тохиолдол гарах учир үнэмлэхтэй болох, ур чадварын дадлагаа дуусгах зэрэг мэдлэг чадвар хэрэгтэй.

Хязгаарлалт бүхий ажил

- Өргөгч цамхаг (5-с доош жинтэй ачаа өргөгч) жолоодох
- Зөөврийн өргөгч цамхаг (1-с доош жинтэй ачаа өргөгч) жолоодох
- Өргөгч цамхагийн өргөх ачааг бэлдэх ажил (1-с бага тонн жинтэй ачаа өргөх өргөгч цамхаг, зөөврийн өргөгч цамхаг зэрэг)
- Сэрээт ачигч зэрэг ачааны машин (хамгийн дээд тал нь 1-с дээш тонн) жолоодох
- Хийн гагнуур
- Барилгын машин жолоодох
- Дээш сунадаг машин жолоодох зэрэг

(4) Ажлын хувцас ба анхаарах зүйл

Төхөөрөмжинд үс болон хувцас орооцлодох аюултай тохиолдолд ажлын малгай болон ажлын хувцас өмсөх шаардлагатай. Ажлын хувцасны бүрэн бүтэн бус байдал нь дараах осолд хүргэнэ:

- Үс орооцлодох -Хувцас орооцлодох -Бүдрэх

Эдгээр ослоос сэргийлэхийн тулд ажлын хувцас, ажлын малгай болон хамгаалалтын гутал зэргийг эв хэвшил болгон өмсөхөд анхаарцгаая.

Эргэлдэх хутганд гар орох аюултай тул бээлий өмсөхгүй байна. Үүнийг анхаарна уу.

(5) Аюулгүйн тоноглол ба хамгаалалтын хэрэгсэл

Аюулгүйн тоноглол ба хамгаалалтын хэрэгсэл нь осол аюулаас таны биеийг хамгаалах хамгийн наад захын зүйлс юм. Ажил дээр хэрэглэх үүрэгтэй бол ямар ч тохиолдолд ажил хийхэд саад болж байна хэмээн тайлах ёсгүй болно.



特別教育が必要な業務

- ・ クレーン（つり上げ荷重5トン未満のもの）の運転
- ・ 移動式クレーン（つり上げ荷重1トン未満のもの）の運転
- ・ 玉掛作業（つり上げ荷重1トン未満のクレーン、移動式クレーンに係るもの）
- ・ フォークリフト等荷役運搬機械（最大荷重1トン以上のもの）の運転
- ・ 動力プレス of 金型等の取付け、取外し、調整
- ・ アーク溶接機を用いる金属の溶接
- ・ ロープ高所作業 など

(3) 就業に関する資格

資格を持たないと就労させることができない業務が定められておています。こうした就業制限業務に従事する場合には、免許の取得や技能講習の修了などの資格が必要となります。

就業制限業務

- ・ クレーン（つり上げ荷重5トン未満のもの）の運転
- ・ 移動式クレーン（つり上げ荷重1トン未満のもの）の運転
- ・ 玉掛作業（つり上げ荷重1トン未満のクレーン、移動式クレーンに係るもの）
- ・ フォークリフト等荷役運搬機械（最大荷重1トン以上のもの）の運転
- ・ ガス溶接等
- ・ 車両系建設機械の運転
- ・ 高所作業車の運転 など

(4) 作業服装の留意点

機械に髪の毛や衣服が巻き込まれるおそれのあるときは、作業帽や作業服を着用することとなっています。作業服の乱れは次のような災害を引き起こします。

- ・ 頭髮の巻き込まれ
- ・ 衣類の巻き込まれ
- ・ つまづき

これらの災害を防ぐためにも作業服や作業帽を正しく身につけ、安全靴などの履物を正しく履くよう心がけましょう。

なお、回転する刃物に労働者の手が巻き込まれるおそれのあるときは、手袋を使用しないこととなっていますので気を付けましょう。

(5) 安全装置と保護具

安全装置や保護具は、危険を伴う作業であなたの身を守る最低限のものです。作業によっては使用を義務付けられていますので、作業がしにくいから外してしまうことは、絶対にしないようにしましょう。



(6) Аюулгүй байдал эрүүл мэндийн тэмдэгтүүд

Аюулгүй байдал ба эрүүл мэндийн тэмдэг нь аюултай газраас сээрмжүүлэн аюулгүй газарт замчлахад тэмдэг ба үгээр дамжуулан мэдэгддэг. Тиймээс энэхүү тэмдэг нь үйлдвэрийн ослоос хамгаалах нэгэн хэрэгсэл болдог.



Тамхи татахыг хориглоно



Хүрч болохгүй



Ил гал гаргах хориотой



Орохыг хориглоно



Аюултай орчин



Өндөр хүчдэлээс болгоомжил



Бүдрэхээс болгоомжил



Анхаар, дээрээс юм унах аюултай



Аюулгүйн бүс зүүх



Хамгаалалтын малгай өмс



Аврах гарц



Гал унтраах хэрэгсэл

17. Япон дахь аж амьдрал

(1) Замын хөдлөгөөний дүрэм

Ур чадварын дадлагажигч нь дугуй унаж явахдаа унах болон зам тээврийн ослоос үүдэн гэмтэл авдаг. Япон улсын замын хөдөлгөөн нь таны байдаг газраас өөр тул Японы замын хөдлөгөөнд суралцан, дагаж биелүүлсэнээр ослоос урьдчилан сэргийлж, хохирлыг багасгах боломжтой.

■ Замын хөдлөгөөний үндсэн дүрэм



- Явган зорчигч ⇒ баруун талаар явна.
- Машин, унадаг дугуй, мотоцикл ⇒ зүүн гараар явна.
- Машин болон явган зорчигчийн явган зорчигч нь давуу эрхтэй.
- Гэрлэн дохио болон замын тэмдгийг дагана уу.

(6) 安全衛生標識

安全衛生標識は、危険な場所の警告や安全な方向に誘導するために、文字や記号を用いて知らせる役割を持っていますので、安全衛生標識もまた労働災害を防止する手段の一つと言えます。



禁煙



接触禁止



火気厳禁



立入禁止



一般禁止



感電注意



障害物注意



頭上注意



安全帯使用



保護帽着用



緊急脱出口



消火器

17. 日本での生活

(1) 交通ルール

技能実習生による自転車走行中の転倒や交通事故による怪我が発生しています。

日本の交通ルールは、あなたの国の交通ルールと同じではありませんから、日本の交通ルールを覚え、守ることで、交通事故を防げたり被害を少なくすることができます。

■基本的な交通ルール



- ・ 歩行者 → 右側通行
- ・ 自動車、自転車、自動二輪 ⇒ 左側通行
- ・ 自動車と歩行者では、歩行者が優先です。
- ・ 信号機と道路標識に従ってください。

■ Явган зорчигчийн дүрэм



- Явган хүний зам, гарц, гүүрэн гарц байгаа тохиолдолд явган зорчигч нь заавал ашиглана.
- Зам хөндлөн гарахдаа явган зорчигчийн тэмдгийг дагана уу.
- Зүүн баруун талаа сайн харж, машин ирж буй эсэхийг нягталсны дараа зам хөндлөн гарна уу.

■ Унадаг дугуйн дүрэм



- Замын зүүн захыг барьж явна уу.
- Унадаг дугуй явж болох тэмдэгтэй замаар явж болно.
- Сундлах, оройн цагаар гэрэлгүй явах, архи уусны дараа унах, гар утсаа нэг гартаа бариад дугуй унаж болохгүй.
- Гэрлэн дохио бүхий уулзвар дээр гэрлэн дохиог харж гарна уу.

■ Жолооны үнэмлэх

Машин, мопед, мотортой дугуй зэргийг жолоодоход Зам тээврийн хөдөлгөөний хууль ёсоор жолооны үнэмлэх шаардлагатай болдог.

■ Гэрлэн дохио

Гэрлэн дохио нь явган зорчигч ба машины гэсэн 2 төрөлд хуваагддаг.

Машины гэрлэн дохио



- Ногоон (нэвтэрч болно)
- Шар (зогсох газар зогсоно уу, хэрэв аюулгүйгээр зогсох боломжгүй бол тэр чигээрээ урагш явна уу)
- Улаан (явахыг хориглоно)

Явган зорчигчийн гэрлэн дохио



- Ногоон (гарч болно)
- Улаан (зогс)

*Зогс гэрэл асахын өмнө гарч болно гэсэн гэрэл нь анивчиж эхлэнэ.

■歩行者のルール



- ・歩道、横断歩道、歩道橋等があるところでは、歩行者は必ずこれらを利用してください。
- ・道路を横断するときは、歩行者用の信号機に従ってください。
- ・道路を横断するときは、左右をよく確認して、車が近づいてこないことを確かめてから横断してください。

■自転車のルール



- ・車道の左端を一列で通行してください。
- ・自転車通行可の道路標識がある歩道では通行することができます。
- ・二人乗り、夜間の無灯火、飲酒運転、携帯電話を使用しながらの片手運転はしないでください。
- ・信号機のある交差点では、信号機に従い通行してください。

■運転免許証

自動車、自動二輪、原動機付自転車などを運転するためには、道路交通法による運転免許証が必要です。

■信号機

信号機には歩行者用と自動車用の2種類があります。

自動車用信号機



- 青緑色 (進んでもよい)
- 黄色 (停止位置で止まれ。ただし、安全に止まれない時は、そのまま進むことができる。)
- 赤色 (進んではいけない。)

歩行者用信号機



- 青緑色 (進め)
 - 赤色 (止まれ)
- ※進めの灯火は、止まれに変化する時間が近づくと点滅します。

■ Замын тэмдгүүд

Гарцаар гарахыг хориглоно



Машин ихтэй газар гарцаар гарахыг хориглосон, аюултай газрыг илэрхийлнэ. Ойрхон байгаа гарцаар гарна уу.

Гарцаар гарах



Зам хөндлөн гарахдаа тэмдэг бүхий ногоон гэрлээр гарцаар гарна уу.

Машины зам



Зөвхөн машин зорчино. Унадаг дугуйтай явган зорчигч, 125 cc цилиндрийн багтаамжтай мопед нь зорчиж болохгүй.

Унадаг дугуй болон явган зорчигчийн зам



гаражинд орох тэрэг болон тусгай зөвшөөрөлтэй машин явж болзошгүй тул анхааралтай байна уу.

(2) Амьдралд хэрэгтэй дүрэм, ёс заншил

Таны эх нутаг болон Япон дахь амьдралын хэв маяг болон аливааг үнэлэх үнэлэмж зөрүүтэй байх нь мэдээжийн хэрэг юм. Японы дүрэм болон ёс заншлыг ойлгож мэдвэл санаа зовох зүйлгүй болно.

Өдөр тутмын амьдралын дүрэм болон ёс заншлыг мэдэж авцгаая:

■ Хог хаях

- Орон нутаг бүр нь тус тусын хог хаях дүрэмтэй байдаг.
- Хогоо ялган, тогтсон өдөр цагт нь гаргаж хаяцгаая.

Хогоо ялгах төрөл(жишээ)

- Шатдаг хог: түүхий хог, цаас зэрэг
- Шатдаггүй хог: шил, шаазан эдлэл, металл зэрэг
- Овор ихтэй хог: тавилга, цахилгаан бараа, унадаг дугуй зэрэг
- Дахин боловсруулах хог: лааз, шил, хуванцар, хуучин цаас зэрэг



■ Галт тэрэг, автобусанд суух тохиолдолд

- Дугаарлан зогсоцгооё
- Галт тэрэг, автобусанд чанга ярьж болохгүй, гар утсаар ярихгүй, утасны дууг унтрааж дүрэм журмаа барьцгаая



■道路標識

横断禁止



自動車の交通量が激しい道路など横断することが禁止されている危険な場所です。近くの横断歩道などを利用しましょう。

横断歩道



道路を横断するときはこの標識の場所で、青信号(青緑色)の時に渡りましょう。

自動車専用道路



自動車専用の道路を示す標識です。歩行者は自転車、排気量125cc以下の自動二輪車等は通行できません。

自転車及び歩行者専用道路



歩行者と自転車用の道路を示す標識です。ただし、車庫に入る車や、特別に許可された車が、歩行者用道路を横切るときもありますので気をつけましょう。

(2) 生活上のルール・マナー

あなたの国と日本では生活習慣や価値観など違うことがありますが、日本と違うのは当たり前のことです。日本のルールやマナーを知れば心配する必要はありません。

日常生活のルールやマナーを早く覚えましょう。

■ゴミの出し方

- ・地域によってゴミ出しのルールが決まっています。
- ・ゴミは分別し決められた日時に捨てましょう。

ゴミの分別の種類(例)

- ・可燃ゴミ: 生ゴミ、紙くずなど
- ・不燃ゴミ: ガラス、陶磁器類、金属製品など
- ・粗大ゴミ: 家具、電気製品、自転車など
- ・資源ゴミ: 缶類、ビン類、プラスチック類、古紙類など



■電車・バスを利用する場合

- ・整列乗車を心がけましょう。
- ・電車・バス内では大声で話さない、携帯電話を使用しないなどのマナーを守りましょう。



■ Байрлах байранд анхаарах зүйлс

- Байрандаа чанга дуугаар хашгирах, чанга дуугаар хөгжим сонсох нь хажуу айлд төвөг учруулна.
- Асуудал гарах магадлалтай учир нэн ялангуяа шөнийн цагаар дээрх зүйлсийг хориглоно.
- Байрны цэвэрлэгээ, эмх цэгцэд анхааран, тогтмол хугацаанд цэвэрлэгээ хийж орчны цэвэр цэмцгэр байдлыг хадгалай.
- Байранд хоол хийж байхдаа агааржуулалтаа асаан, гал унтарсан эсэхийг нягтлах дадлыг хэвшүүлье.
- Байрны гал тогооны хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл, газны хэрэгслийг зөв зохистой ашиглай.



(3) Эрүүл мэндтэй холбоотой мэдлэг

i. Японы цаг агаар, улиралд дасцгаа:

Япон нь 3-5 сар хүртэл үргэлжлэх хавар, 6-8 сар хүртэл үргэлжлэх зун, 9-11 сар хүртэл үргэлжлэх намар болон 12-2 сар хүртэл үргэлжлэх өвөл гэсэн 4 улиралтай. Орон нутаг бүрээр өөр өөр байдаг ч зун нь 30°C-с дээш хэмийн бүгчим халуун, өвөл нь 0°C-с доош хэм хүрэх тохиолдол байдаг. Тиймээс халуун хүйтэнд хувцасаа зөв тохируулж өмсөн, халуун хүйтнээс өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй.

Улирал солигдоход температурын хэлбэлзэл их өндөр байх тул өвчин тусахгүй байхын тулд өдөр бүр амьдралын зөв дэглэм баримтлах нь чухал.

ii. Хоол сайн идэх

Японы хоолыг идэж чадахгүй ч хүмүүс байгаа байх. Гэвч өглөө, өдөр, оройны хоолыг зөв тохируулж идэх нь эрүүл мэндээ хамгаалах үндэс болно. Японы хоол унд нь цаг улиралдаа таарсан байдаг тул бага багаар дасан зохицох нь чухал. Хааяа өөрийн орны хоолыг бүгдээрээ нийлж хийж идэх нь жаахан ч гэсэн сэргээш болно.

Өдөр бүр нэгэн төрлийн хоол идэх нь өвчний шалтгаан болох учир аль болох хоол тэжээлийн тэнцвэртэй байдлыг хадгалах нь чухал.

iii. Амьдралын хэмнэл

Унтах нойрыг сайн авахгүй бол оюун ухааны төвлөрөлт муудаж, ур чадварын дадлагаас гадна өдөр тутмын амьдралд саад болно. Тиймээс өглөө тогтмол цагт босч, хоол тэжээлийн тэнцвэртэй хоол идэж, өдрийн цагаар дадлагаадаа бүрэн анхаарч шөнө орой нь сайн унтаж амрах хэрэгтэй. Шөнө орой болтол компьютер, зурагт болон гар утасны дэлгэцийг урт цагаар ширтэх нь нойргүйдэлд хүргэх тул цагийг тохируулах нь чухал.

Амьдралын зөв хэв маягийг бий болгон Япон дахь амьдралд дасан зохицоё.

iv. Ариун цэврийг сахих нь

Гар угаах, хоолойгоо зайлах нь хянаад томуунаас гадна халдварт өвчнөөс сэргийлэх тул гаднаас ирэнгүүтээ гараа угаах, хоолойгоо зайлах хэвшил бий болгоё.

Байрны цэвэрлэгээ, ор дэвсгэрийн даавууг солих, хөнгөлөө гадаа гаргаж хатаах, угаах нь эрүүл мэндэд тустай тул төвөгшөөлгүйгээр хийцгээе.

v. Санал бодлоо хуваалцах хүнтэй болох

Таны санал бодлыг ур чадварын дадлага удирдагч аж амьдралын зөвлөгөө өгөгч нар сонсоно. Бага хэмжээний санаа зовнилыг том хэмжээнд хүрэхгүйн тулд даруйхан шийдвэрлэх хэрэгтэй.

Аж амьдралын зөвлөгөөнөөс гадна хамт ажиллаж байгаа ур чадварын дадлагагичт болон удирдагч нартайгаа зөвлөлдөж болох хүнтэй болох нь чухал юм.

vi. Японы амьдрал болон соёлтой танилцах нь

Танай улсад байдаг зүйл Японд байхгүй бол байхгүй зүйлийг шаардсаар туйлын таагүй болно. Тиймээс өөрийн сэтгэлд нийцэх Японд байгаа спорт, баярт оролцох нь зөв болов уу. Нэн ялангуяа дадлага хэрэгжүүлэгч газар болон хянагч байгууллага нь орон нутгийн арга хэмжээ, сайн үйлсийн төлөөх арга хэмжээнд оролцох боломжийг олговол аль болох идэвхитэй оролцон, орон нутгийн хүмүүстэй нөхөрлөцгөө.

vii. Өвдсөн тохиолдолд бэлэн байх талаар

Өвчин тусах эсвэл гэмтэл авч магадгүй тул үзүүж болох эмнэлгийг урьдаас шалгая. Эмнэлэг явах үедээ өөрийнхөө талаарх мэдээллээ түргэн шуурхай өгөхийн тулд, овог нэр, төрсөн он сар өдөр, одоо эмчлүүлж байгаа өвчин байгаа эсэх, одоо ууж буй эм байгаа эсэх, аллергитэй эсэх зэргийн талаар урьдчилан тэмдэглэл хийж авч үлдэгчээ.

■ 宿舎内での注意事項

- ・ 宿舎内で大声で騒いだり、大きな音で音楽を聴いたりすると近隣の迷惑になります。
- ・ トラブルになることもありますので、特に深夜の時間帯は注意しましょう。
- ・ 宿舎内は整理整頓を心がけ、定期的に掃除をするなどして清潔な環境を保ちましょう。
- ・ 調理中は換気気を付け、火の元を確認する習慣をつけましょう。
- ・ 調理器具、電気器具、ガス器具等は正しく使用しましょう。



(3) 健康に関する知識

① 日本の風土・気候になれよう

日本には、春(3～5月)・夏(6～8月)・秋(9～11月)・冬(12～2月)の四季があります。地域によって違いますが、夏は30℃を超えてむし暑く、冬は寒く0℃以下になるところもあります。このような気温の変化には衣服で調節するなどして「暑さ」、「寒さ」対策を行ってください。

また、季節の変わり目は気温の変化が大きくなり体調を崩しがちになりますので、常日頃から規則正しい生活を心がけましょう。

② 食事をしっかりとろう

日本の食事が口に合わないという人もいるでしょう。しかし、朝昼晩の食事を規則正しく取るとは、健康管理の基本です。日本食は日本の気候風土や生活に合った食事ですから、少しずつ慣れていきましょう。そして、時には母国の料理を作って技能実習生同士で食事をする事でリフレッシュしましょう。

毎日同じ食品や料理など偏った食事をしていると病気の原因にもなりますので、栄養のバランスを考えた食事をとりましょう。

③ 生活のリズム

睡眠を十分にとらないと集中力がなくなり、技能実習のみならず日常生活にも支障をきたしてしまいます。そうならないように朝は定時に起きて、規則正しい食事をして、日中は技能実習に励んだら夜はしっかりと睡眠を取りましょう。夜遅くまでパソコン、テレビ、携帯電話の画面を長時間見ていると眠れなくなってしまいますのでほどほどにしましょう。

規則正しい生活のリズムをつくり日本での生活に慣れるようにしましょう。

④ 衛生に気をつけよう

手洗い・うがいはかぜやインフルエンザの他に様々な感染症を予防するために効果的です。外先から戻った場合は、手洗い・うがいを習慣にしましょう。

また、宿舎の掃除やシーツの取替え、ふとんの日干し、洗濯なども健康を維持するために重要なことですから、面倒がらずにこまめにしましょう。

⑤ 相談相手を見つけよう

あなたの相談に乗ってくれるのが、技能実習指導員、生活指導員や相談員です。小さな不安は大きくならないうちに相談して、解決するようにしましょう。

また、生活指導員以外にも技能実習生仲間やリーダーなど相談できる人が見つけられるといいですね。

⑥ 日本の生活と文化にふれよう

あなたの国にあって、日本に無いものばかりを求めると欲求不満がつのります。日本にある遊びやスポーツ、祭りなどで、あなたの興味のあるものに積極的に接すると良いでしょう。特に、実習実施者や監理団体が地域のイベントや慈善活動などの催しへの参加の機会を提供してくれる場合には、積極的に参加して、地域の人たちと交流を持ちましょう。

⑦ 病気に備えて

病気やケガに備えて自分が安心して行ける病院を確認しておきましょう。

いつ病気になったり、いつケガにあうかわかりませんから、病院に行った際に自分の情報をすぐに伝えられるように、氏名、生年月日、現在治療中の病気の有無、現在服用中の薬の有無、アレルギーの有無などについて、メモしておくのがいいでしょう。

(4) Япон дахь өдөр тутмын амьдралд хэрэгт болох тэмдэглэл

i. Яаралтай үед болон хэрэг болох утасны дугаар

Яаралтай үед хэрэгт болох утасны дугаар		Бусад энгийн мэдээлэл авах утасны дугаар	
Цагдаагийн газар	110 (үнэгүй)	Цаг агаарын мэдээ	177 (үнэтэй)
Гал түймэр, түргэн тусламж	119 (үнэгүй)	Цагийн талаарх мэдээлэл	117 (үнэтэй)
Утас эвдрэхэд	113 (үнэгүй)	Утасны дугаар шалгах	104 (үнэтэй)

ii. Олон улсын дугаар ашиглах

Утасны дугаарыг дараах дэс дарааллаар залган олон улстай холбогдогцоо:



Жишээлбэл: KDDI-г хэрэглэн Хятадын 0123-4567 дугаарт залгах бол:

(өөрийн дугаар) (улсын дугаар) (орон нутгийн дугаар) (утасны дугаар)



* Олон улсын ярианы дугаарын эхлэл жишээ

KDDI ХХК	001
Софтбанк телеком ХХК	0061
NTT Комюникейшонз ХХК	0033

* Олон улсын ярианы эрх ашиглан бусад улс руу залгах улсын дугааруудаас

Улсын нэр	Улсын дугаар	Улсын нэр	Улсын дугаар
Япон	81	Тайланд	66
Хятад	86	Шри Ланк	94
Вьетнам	84	Лаос	856
Индонез	62	Монгол	976
Филиппин	63	Перу	51

iii. Олон улсын энгийн шуудангийн тариф (агаарын шуудан)

Бүс нутаг		1-р бүс	2-р бүс	3-р бүс
Бүс нутгийн нэр		Ази - Хятад - Филиппин - Индонез - Тайланд - Вьетнам зэрэг	Номхон далай дахь арлууд Ойрх Дорнод Хойд Америк Төв Америк Европ	Африк Өмнөд Америк
Захидал	25гр хүртэл	90 иен	110 иен	130 иен
(Стандарт бүс)	50гр хүртэл	160 иен	190 иен	230 иен
Ил захидал		70 иен тогтмол үнэ		

(4) 日本の生活便利メモ

①緊急時、生活情報の電話番号

緊急時の電話番号		生活情報の電話番号	
警察	110 (無料)	天気予報	177 (有料)
火事・救急車	119 (無料)	時報	117 (有料)
電話の故障	113 (無料)	電話番号調べ	104 (有料)

②国際電話のかけかた

電話番号は次の順序でかけると、世界中のどこにでもつながります。



例: KDDIを使用した場合、中国の0123-4567番にかける時には、次のようになります。

(申込番号) (国番号) (市外番号) (電話番号)



※国際電話申込番号の例

KDDI (株)	001
ソフトバンクテレコム (株)	0061
NTTコミュニケーションズ (株)	0033

※国際電話の国番号の一例

国名	国番号	国名	国番号
日本	81	タイ	66
中国	86	スリランカ	94
ベトナム	84	ラオス	856
インドネシア	62	モンゴル	976
フィリピン	63	ペルー	51

③国際通常郵便料金 (航空便)

地域		第1地域	第2地域	第3地域
地域名		アジア ・中国 ・フィリピン ・インドネシア ・タイ ・ベトナム など	オセアニア 中近東 北米 中米 欧州	アフリカ 南米
手紙	25gまで	90円	110円	130円
(定型)	50gまで	160円	190円	230円
郵便はがき		70円均一		

iv. Гадаад руу мөнгө илгээх талаар

Хуулиар ийм төрлийн үйлчилгээ явуулах хотын банк (хуулийн дагуу мөнгө илгээх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй газрууд мөн багтана) зэрэг нь гадаад руу Японоос мөнгө илгээх үйлчилгээ үзүүлнэ. Энэ нь хууль бус аргаар гадаад руу мөнгө гуйвуулахаас сэргийлэхийн тулд юм. Гадаад руу мөнгө илгээхэд заавал хувь хүний бичиг баримт болон паспорт шаардлагатай болно.

Ур чадварын дадлагажигч та эх орон руугаа мөнгө шилжүүлэх тохиолдолд заавал дээрх банкуудаар дамжуулан үйлчлүүлнэ үү. Банкнаас гадуур гадаад руу мөнгө шилжүүлсэн тохиолдолд хуулийн дагуу торгууль ноогдуулж болох тул ийм төрлийн үйлдлээс зайлсхийх нь зүйтэй.

18. Хувийн дугаар

Ур чадварын дадлагажигч нь Японд ирсэнээс хойш 14 хоногийн хугацаанд өөрийн “шилжин ирсэн хаяг”-аа холбогдох засаг захиргаанд мэдүүлнэ. Засаг захиргаа тус мэдүүлгийг хүлээн авсны дараа “оршин суугчийн хуудас”-г боловсруулан гаргаж, 12 оронтой дугаар бүхий “хувийн дугаар”-ыг олгоно. “Хувийн дугаар”-ыг Япон дахь нийгмийн баталгаа болон татвар, ослын үеэр зэрэг 3 төрлөөр хэрэглэх тул дараах зүйлсийг анхааралтай уншина уу:

